



**ЭРҮҮЛ ХҮНСЭЭР
ДЭЛХИЙГ ДАЙЛНА**





АЛСЫН ХАРАА

Эрүүл хүнсээр дэлхийг дайлна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид хамтдаа байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор чанартай, эрүүл, аюулгүй хүнсийг үйлдвэрлэн, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээдлэн ажиллана.

ҮНЭТ ЗҮЙЛ

- Х** ХҮНДЭТГЭЛ - Байгууллагын соёл
- У** УР ЧАДВАР - Хүний нөөцийн бодлого
- Ш** ШИНЭ САНАА - Стратеги
- Х** ХАМТЫН ХҮЧ - Дотоод журам
- А** АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА - ХАБ
- Н** НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА - Байгаль хамгаалал



ЭРҮҮЛ ХҮНСЭЭР ДЭЛХИЙГ ДАЙЛНА



Хүний биед шим тэжээлтэй амин дэм, уураг, тос агууламж хамгийн өндөртэй монгол хуш модны самрыг “Nord Road” компани 2014 оноос эхлэн байгальд ээлтэй аргаар боловсруулж, нэмүү өртөг шингээн “Хушхан” брэндийг бүтээж, дотоодын төдийгүй дэлхийн зах зээлд гаргаж байна.

“ХУШХАН” БРЭНДИЙГ ЕВРОПЫН 4, АЗИЙН 2 УЛСАД ТОГТМОЛ ЭКСПОРТОЛЖ БАЙНА



МАНАЙ КОМПАНИ 2016-2021 ОНД НИЙТ


БАЙГАЛИЙН НӨӨЦ
АШИГЛАСНЫ ТӨЛБӨРТ

6.3 тэрбум
төгрөг

ЭКСПОРТТОЙ ХОЛБООТОЙ
ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨРТ

7.9 тэрбум
төгрөг





МОНГОЛ ОРНЫ
НИЙТ ГАЗАР
НУТГИЙН

8.0%

ойгоор
бүрхэгдсэн
байдаг

ТҮҮНИЙ

5.5% → 630.1 мян.га

буюу

талбайг хушин ой бүрдүүлдэг

МҮХАҮТ-ын тооцооллоор
Монгол Улсын хэмжээнд жилд

8,000-10,000 тн

хушны самар экспортлох боломжтой



NORD
ROAD
LLC

Манай компани сүүлийн 7 жилийн хугацаанд монгол хушны самрыг дэлхийн зах зээлд экспортолж, нөхөн сэргээгдэх экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг тэлж байна

ХУШ МОД НЬ ДАРААХ УЛС ОРНУУДАД УРГАДАГ



Испани



Португал



Франц



Турк



Итали



Канад



Хятад



Өмнөд
Солонгос



Умард
Солонгос



Орос



Монгол оронд ургадаг хуш модны самар нь хүний биед шаардлагатай амин дэмээр хамгийн баялаг болох нь тогтоогдсон.



Хүний тархи болон зүрхний эрүүл мэндийг дэмждэг



тэргүүтэй нийт 19 нэр төрлийн амин хүчил **МОНГОЛ ХУШ МОД**ны самрын идээнд агуулагддаг.

Хушны самрыг

ЦӨМӨХ → **ЦЭВЭРЛЭХ** → **СОРТЛОХ**
болон
САВЛАХ

гэсэн үйлдвэрийн **3 цехээр** дамжуулан, нийт **20 дамжлагаар** боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.



3-4тн

эцсийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх хүчин чадалтай. /хоногт/

ТҮҮХЭН ЗАМНАЛ

2015

Хушхан брэндийн үйлдвэрийг анх ашиглалтад оруулав.

2016

Монгол хуш модны самрын анхны экспортыг БНХАУ улс руу хийлээ.

2020

“Хушхан” брэндийг үүсгэж, самар, чөмгийг 50-500 граммаар савлан, арваннэгдүгээр сараас эхлэн дотоодын зах зээлд нийлүүлж эхлэв. Мөн хүнсний аюулгүй байдлын HACCP, чанарын менежментийн тогтолцооны ISO 9001 олон улсын стандартуудыг үйлдвэрлэлдээ нэвтрүүллээ.

2020

Түүнчлэн хуш мод, түүний самрын судалгааны ажлуудыг өргөн цар хүрээтэй эхлүүлэв. Үрийн генетикийн судалгаа, Хуш модны анатоми, физиологийн судалгаа, Самар бэлтгэх бэлтгэл нь хуш модны насжилт, өсөлтөд үзүүлэх нөлөөллийн судалгаа, Самарыг зөв зохистой бэлтгэх аргачлалын судалгаа зэргийг үүнд дурдаж болно.

2021

Үйлдвэрлэл, үйл ажиллагаандаа олон улсын Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 22000:2019, Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2018 зэрэг стандартыг нэвтрүүлэх ажил эхлүүлээд байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



01.

Байгалийн нөхөн сэргээгдэх баялагт нэмүү өртөг шингээн, экспортын ШИНЭ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй “Nord Road” компани нийгмийн хариуцлагын хүрээнд,

- Ёс зүйтэй
- Сайн засаглалтай
- Байгаль дэлхийгээ хайрладаг компани байхыг эрмэлзэж байна.

02.

2020, 2021 онд нийт 100,000 хуш мод Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд тарив.

03.

Хуш модны самраар олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бүтээгдэхүүний үнэ цэнийг өсгөх, улмаар байгальд ээлтэй бизнес моделийг нутагшуулахыг зорьж байна.



ШИНЭ ТӨСЛҮҮД



Хуш модны самарт нэмүү өртөг шингээн, байгальд ээлтэй технологиор боловсруулахдаа **ХАЯГДАЛГҮЙ** үйлдвэрлэл хөгжүүлэхийг зорьж байна. Тухайлбал, инновац нэвтрүүлэн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн байдлаар хэрэглэх боломжтой бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг эрмэлзэж, шинжлэх ухааны суурь судалгаануудыг эхлүүлээд буй.

Хуш модны самраар:

- Тос
- Сүү
- Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх


Мөн самрын яс, хальс зэрэг дайвар түүхий эдийг ашиглан бусад ангиллын эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг эрэлхийлж байна.

Монгол хуш модны самраар 100% хаягдалгүй үйлдвэрлэл эрхэлнэ.



**Байгалиа хамгаалж,
баялгаа бүтээнэ**

#хушхан





📍 Эмээлтийн зүүн 452, СХДүүрэг
Улаанбаатар хот, Монгол Улс

☎ 7717-3399

✉ info@nordroad.mn

🌐 www.hushkhan.mn

